



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/21

Хужирт сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дулаан 6 дугаар багийн нутаг дэвсгэр “Бага цагаан сайр” гэх газар нутаглаж байгаа малчин Б.Отгонбаярын 1 нохойнд мал, амьтны халдварт галзуу өвчний шинж тэмдэг илэрч Мал эмнэлгийн тасгийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр саналаар 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 14 хоног хязгаарлалтын дэглэм тогтоосугай.
2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт байгаа 4 хот айлын 8 өрхийн 3284 бог мал, 566 бод малыг галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулж, ариутгал халдваргүйжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг “Гуахарз” мал эмнэлгийн малын их эмч (Д.Даваасүрэн), тухайн өрхийн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхийг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Э.Оюунпүрэв), ойр орчимд нутаглаж байгаа айл өрхүүдэд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэхийг Дулаан 6 дугаар багийн Засаг дарга (Ц.Амгалан) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Холбогдох заавар журмын дагуу хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа), Эрэн хайх, аврах бүлгийн дарга аврах ажиллагсааны зааварлагч, дэслэгч Б.Баярсайхан, уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа), Цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч, дэслэгч (Э.Баатарлхагва) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ